

## ТАТВАРЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

20... оны ... сарын ....өдөр

Дугаар

Улаанбаатар хот

Падаан, баримт, гэрчилгээний загвар, албан татвар суутган төлөгч болон албан татвар төлөгчийг бүртгэх, бүртгэлээс хасах журам батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Татварын ерөнхий хуулийн 77 дугаар зүйлийн 77.7.3, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.11 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Нэмэгдсэн өртгийн албан татварын падаан”, Нэмэгдсэн өртгийн албан татварын падааныг хэрэглэх зааврыг 1 дүгээр хавсралтаар, “Дахин давтагдашгүй төлбөрийн дугаарын тодорхойлолт”-ыг 2 дугаар хавсралт, Урьдчилж орсон орлого /гарсан зарлага/-ын баримтыг 3 дугаар хавсралт, “Нэмэгдсэн өртгийн албан татвар суутган төлөгчийг бүртгэх, бүртгэлээс хасах журам”-ыг 4 дүгээр хавсралт, “Нэмэгдсэн өртгийн албан татвар суутган төлөгчөөр бүртгүүлэх өргөдөл” (Маягт ТТБ-01а)-ыг 5 дугаар хавсралт, “Нэмэгдсэн өртгийн албан татвар суутган төлөгчийн гэрчилгээ”-г 6 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Тушаалыг үйл ажиллагаандаа мөрдөж, хяналт тавьж, програмчлах ажлыг зохион байгуулж ажиллахыг Татварын ерөнхий газрын Татвар төлөгчтэй харилцах газар (Д.Цогзолмаа), Мэдээлэл технологи статистикийн төв (Х.Батбаяр), нийслэл, дүүргийн татварын газар, хэлтсийн дарга нарт үүрэг болгосугай.

3. Гааль, татварын ерөнхий газрын даргын батласан 2016 оны 01 дүгээр сарын 18-ны өдрийн А/22 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА

Б.ЗАЯАБАЛ

НЭМЭГДСЭН ӨРТГИЙН АЛБАН  
ТАТВАРЫН ПАДААН №

Дахин давтагдашгүй төлбөрийн дугаар: ..... 20.... оны ... сарын .... өдөр

Албан татвар суутган төлөгч борлуулагчийн: Худалдан авагчийн:

Нэр: ..... Нэр: .....

Регистрийн дугаар:  Регистрийн дугаар:

Татвар төлөгчийн дугаар:  Татвар төлөгчийн дугаар:

Хаяг:..... Хаяг:.....

Д/д	Бараа, ажил, үйлчилгээний нэр	Код	Хэмжих нэгж	Тоо, хэмжээ	Нэгжийн үнэ, төгрөг	Бүгд үнэ төгрөг

Тамга

- Бараа, ажил, үйлчилгээний үнэ
- Нэмэгдсэн өртгийн албан татвар
- Нийт үнэ



Хүлээлгэн өгсөн ...../...../ Хүлээн авсан ...../...../

(гарын үсэг) нэр (гарын үсэг) нэр

**Тайлбар:** Нэмэгдсэн өртгийн албан татварын падаан нь хэвлэхэд тодорхой нууцлал агуулсан, 210х297 см-ийн хэмжээтэй QR кодтой байна. Бараа, ажил, үйлчилгээний код нь бараа, үйлчилгээг "Barcode"-ийн GS1-13 ангиллын код, Үндэсний статистикийн хорооноос баталсан "Бүтээгдэхүүн, үйлчилгээний нэгдсэн ангилал"-ын кодоод үндэслэн тодорхойлсон 4 орон бүхий код байна.

Нэмэгдсэн өртгийн албан татварын  
падааныг хэрэглэх заавар

1. Нэмэгдсэн өртгийн албан татварын падаан (цаашид “падаан” гэх) гэж Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.13-т заасныг хэлнэ.

2. Бараа, ажил, үйлчилгээний код гэдгийг “Barcode”-ийн GS1-13 ангиллын кодтой барааны хувьд уг кодыг, GS1-13 кодгүй бараа, ажил, үйлчилгээний хувьд Үндэсний статистикийн хорооноос баталсан “Бүтээгдэхүүн, үйлчилгээний нэгдсэн ангилал”-ын бүтээгдэхүүн, үйлчилгээг тодорхойлсон кодыг ойлгоно. Дээр дурдсан кодыг хураангуйлсан хэлбэрээр хэрэглэж болно.

3. Падаан нь нэмэгдсэн өртгийн албан татвар суутган төлөгч (цаашид “албан татвар суутган төлөгч”)-өөр бүртгэгдсэн этгээдийн төсөвт төлөх болон бэлтгэн нийлүүлэгчид төлсөн нэмэгдсэн өртгийн албан татварын хасалтыг тодорхойлж, тайлан гаргах үндэслэл болно.

4. Падааныг зөвхөн албан татвар суутган төлөгчөөр бүртгэгдсэн этгээд хэрэглэх бөгөөд падааны дахин давтагдашгүй төлбөрийн дугаарыг татварын албаны нэгдсэн системээс олгоно.

5. Албан татвар суутган төлөгч нь бараа, ажил, үйлчилгээгээ борлуулсан тухай төлбөрийн баримтад үндэслэн падааныг нэгдсэн системд үүсгэх бөгөөд системээс падааныг хэвлэх, худалдан авагчид илгээх боломжтой байна. Падааныг нэг эсхүл хэд хэдэн төлбөрийн баримтыг хамтатган үүсгэж болно.

6. Нэгдсэн системээс хэвлэн гаргасан болон системд үүссэн тодорхой нууцлалтай QR код бүхий падааныг хүчин төгөлдөр баримт гэж үзнэ.

7. Бараа, ажил, үйлчилгээг борлуулсан түүнчлэн худалдан авсан албан татвар суутган төлөгч нь борлуулалтад ногдуулсан болон худалдан авалтын хасалт хийх нэмэгдсэн өртгийн албан татварыг тухайн падаан бичсэн сарын нэмэгдсэн өртгийн албан татварын тайланд тусгана. Харин зээлээр худалдан авалт хийсэн албан татвар суутган төлөгч нь падааныг төлбөрийг бүрэн төлсөн сарын тайланд тусгана.

## ДАХИН ДАВТАГДАШГҮЙ ТӨЛБӨРИЙН ДУГААРЫН ТОДОРХОЙЛОЛТ

Дахин давтагдашгүй төлбөрийн дугаар гэж Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.15-д заасан худалдаа, үйлчилгээ эрхлэгчийн татвар төлөгчийн дугаар, салбар, төлөөний газрын дугаар, төлбөр тооцооны он, сар, өдөр, төлбөр тооцооны дэс дугаарыг дунд нь ямар нэг тэмдэгт хэрэглэлгүйгээр үргэлжлүүлэн тоон утгаар илэрхийлсэн дугаарыг хэлнэ.

Дахин давтагдашгүй төлбөрийн дугаарыг нэмэгдсэн өртгийн албан татварын падаан болон төлбөрийн баримтад тусгана.

Нэмэгдсэн өртгийн албан татварын падаанд хэрэглэх дахин давтагдашгүй төлбөрийн дугаар гэж тодорхойлолтод тусгасан мэдээллийг агуулсан, үргэлжилсэн тоон утгаар илэрхийлсэн, нэгдсэн системээс олгосон давтагдахгүй дугаарыг хэлнэ.

Төлбөрийн баримтад хэрэглэх дахин давтагдашгүй төлбөрийн дугаар гэж тодорхойлолтод тусгасан мэдээллийг агуулсан, тоон утгаар илэрхийлсэн, нэгдсэн системээс олгосон давтагдахгүй дугаарыг хэлнэ.

УРЬДЧИЛЖ ОРСОН ОРЛОГО /ГАРСАН ЗАРЛАГА/-ЫН БАРИМТ

Дахин давтагдашгүй төлбөрийн дугаар: ..... 20.... оны ... сарын .... өдөр

Албан татвар суутган төлөгч борлуулагчийн: Худалдан авагчийн:

Нэр: .....

Нэр: .....

Регистрийн дугаар:

Регистрийн дугаар:

Татвар төлөгчийн

Татвар төлөгчийн

дугаар:

дугаар:

Хаяг:.....

Хаяг:.....

Д/д	Бараа, ажил, үйлчилгээний нэр	Код	Хэмжих нэгж	Тоо, хэмжээ	Нэгжийн үнэ, төгрөг	Бүгд үнэ төгрөг

Тамга

- Бараа, ажил, үйлчилгээний үнэ
- Нэмэгдсэн өртгийн албан татвар
- Нийт үнэ



Хүлээлгэн өгсөн ...../...../

Хүлээн авсан ...../...../

(гарын үсэг) нэр

(гарын үсэг) нэр

Тайлбар:

- Урьдчилж орсон орлогын буцаалт нь “хэсэгчлэн буцаах” болон “нийт дүнгээр буцаах” гэсэн сонголттой байна. Буцаалтыг борлуулагч талаас хийх эрхтэй байна. Бизнесийн үйл ажиллагаанд гаргасан баримт бол “борлуулагч болон худалдан авагч”-ийн нэр, регистрийн дугаар, байгууллагын хаяг, утасны дугаар байх бөгөөд тухайн баримт борлуулагч талд “Урьдчилж орсон орлого” худалдан авагч тал “Урьдчилж гарсан зардал” гэсэн нэрээр харагдана.
- Хувь хүнд гаргасан бол ДДТД дугаараар иргэн өөрийн хувь хүний ЦТБС-д баталгаажуулах бөгөөд баримт баталгаажуулсан иргэний аппликэйшн болон ЦТБС-ийн “Урьдчилж гарсан зардал” хэсэгт бүртгэгдэнэ.
- Тухай хэвлэсэн баримтыг нэмэгдсэн өртгийн албан татварын төлбөрийн баримт гэж үзэхгүй бөгөөд зөвхөн орлогоор хүлээн зөвшөөрсөн тохиолдолд борлуулалтын болон худалдан авалтын төлбөрийн баримт /НӨАТ суутган төлөгчөөс худалдан авалт хийсэн бол иргэнд 20 урамшуулал олгохоор тооцогдоно, НӨАТ суутган төлөгч биш газраас худалдан авалт хийсэн бол сугалааны дугаартай баримт/, падаан үүснэ.
- Урьдчилж орсон орлогыг борлуулалтын орлогод хүлээн зөвшөөрсөн тохиолдолд борлуулагч талаас “Орлогод бүртгэх” хүсэлтийг илгээх бөгөөд худалдан авагч тал зөвшөөрсөн тохиолдолд төлбөрийн баримт 2 талд үүснэ. /Иргэн өөрийн ЦТБС болон аппликэйшнээр зөвшөөрөх боломжтой байна./

## НЭМЭГДСЭН ӨРТГИЙН АЛБАН ТАТВАР СУУТГАН ТӨЛӨГЧИЙГ БҮРТГЭХ, БҮРТГЭЛЭЭС ХАСАХ ЖУРАМ

### Нэг. Ерөнхий зүйл

1.1.Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн дагуу нэмэгдсэн өртгийн албан татвар суутган төлөгч /цаашид “албан татвар суутган төлөгч” гэх /-өөр бүртгүүлэх үүрэг хүлээсэн хувь хүн, хуулийн этгээдийг татварын алба албан татвар суутган төлөгчөөр бүртгэх, бүртгэлд нэмэлт өөрчлөлт оруулах, бүртгэлээс хасахад энэхүү журмыг баримтална.

1.2.Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2.5 -д заасан Монгол Улсад оршин суугч бус этгээдийн хувьд нэмэгдсэн өртгийн албан татвар суутгагчаар бүртгэхгүй бөгөөд тухайн этгээдийн татвар төлөх, тайлагнах үүргийг Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.2-т заасны дагуу уг этгээдээс ажил, үйлчилгээ худалдан авсан хувь хүн, хуулийн этгээд хариуцан гүйцэтгэнэ.

### Хоёр. Эрх зүйн үндэслэл

2.1.Татварын алба дараах үндэслэлээр хувь хүн, хуулийн этгээдийг албан татвар суутган төлөгчөөр бүртгэнэ. Үүнд:

2.1.1.Хувь хүн, хуулийн этгээдийн үйл ажиллагааны (Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 13 дугаар зүйлд заасан чөлөөлөгдөх бараа, ажил, үйлчилгээний болон хөрөнгөөр бүртгэлтэй байсан үндсэн хөрөнгийн борлуулалтаас бусад) борлуулалтын орлогын хэмжээ 50.0 сая ба түүнээс дээш төгрөгт хүрсэн нь анхан шатны баримтаар нотлогдсон;

2.1.2.Татварын хяналт шалгалтаар нэмэгдсэн өртгийн албан татвар ногдох орлогын хэмжээ 50.0 сая ба түүнээс дээш төгрөгт хүрсэн нь нотлогдсон;

2.1.3.Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.5-д заасны дагуу хувь хүн, хуулийн этгээд нь сайн дураар албан татвар суутган төлөгчөөр бүртгүүлэх хүсэлтээ татварын албанд гаргасан;

2.1.4.Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4-д заасны дагуу зохион байгуулалтын төрөл хэлбэрээ өөрчлөн байгуулагдсаны дүнд

бий болсон хуулийн этгээд нь албан татвар суутган төлөгчөөр бүртгүүлэх хүсэлтээ татварын албанд гаргаж болно.

2.1.5.Хувь хүн, хуулийн этгээдийн үйл ажиллагааны борлуулалтын орлогод урьдчилж орсон орлого хамаарахгүй.

2.1.6.Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3 дахь хэсэгт заасны дагуу албан татвараас чөлөөлөгдөх бараа, ажил, үйлчилгээг дагнан эрхэлж байгаа хувь хүн, хуулийн этгээд нь дараах нотлох баримтыг цахим болон цаасан хэлбэрээр тайлант жилийн дараа сарын 10-ны дотор харьяалах татварын албанд жилд нэг удаа ирүүлнэ: Үүнд: /албан татвар суутган төлөгчөөр бүртгүүлэх үүргээс чөлөөлөгдөх хүсэлт, чөлөөлөгдөх бараа, ажил, үйлчилгээ эрхэлдэг болохыг нотлох баримт, аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл, цахим төлбөрийн баримт, гэрээ, анхан шатны баримт гэх мэт/.

2.1.7.Энэ журмын 2.1.6-д зааснаар албан татвар суутган төлөгчөөр бүртгэгдэхгүй хувь хүн, хуулийн этгээд нь нэмэгдсэн өртгийн албан татвар ногдох бараа, ажил, үйлчилгээг давхар эрхэлсэн тохиолдолд албан татвар суутган төлөгчөөр бүртгэгдэнэ.

#### Гурав. Тавигдах шаардлага

3.1.Албан татвар суутган төлөгчөөр бүртгүүлэх хүсэлт гаргасан хувь хүн, хуулийн этгээд нь дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

3.1.1.Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2.1, 5.2.3, 5.6-д заасан;

3.1.2.Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.5-д заасан нөхцөл хангаж сайн дураар албан татвар суутган төлөгчөөр бүртгүүлэх хувь хүн, хуулийн этгээдийн хувьд зөвхөн нэмэгдсэн өртгийн албан татвар ногдох үндсэн үйлдвэрлэл, ажил, үйлчилгээний борлуулалтын орлогын хэмжээ нь 10.0 сая ба түүнээс дээш төгрөгт хүрсэн нь анхан шатны баримтаар нотлогдсон байх;

3.1.3.Энэ журмын 2.1.4-д заасан этгээдийн хувьд өөрчлөн байгуулсан тухай эрх бүхий этгээдийн тушаал, шийдвэр, хуваах тусгаарлах замаар өөрчлөн байгуулагдсан компанийн тухайд хуваах баланс, компанийн дүрэм зэрэг өөрчлөн байгуулалтын дүнд татвар төлөх эрх, үүрэг шилжсэнийг нотлох баримтыг үндэслэнэ.

#### Дөрөв. Нэмэгдсэн өртгийн албан татвар суутган төлөгчөөр бүртгэх, гэрчилгээ олгох

4.1.Хувь хүн, хуулийн этгээд нь Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх заалтад заасны дагуу анхан шатны баримтаар нотлогдсон

өдрөөс хойш ажлын 10 өдөрт багтаан харьяалах татварын албанд бичгээр болон цахим хэлбэрээр "Нэмэгдсэн өртгийн албан татвар суутгагчаар бүртгүүлэх өргөдөл" / Хавсралт №5 /-ийг бөглөж дараах баримтыг хавсарган харьяалах татварын албанд ирүүлнэ. Үүнд: Үйл ажиллагааны борлуулалтын орлогын хэмжээ нь 50.0 сая ба түүнээс дээш төгрөгт хүрснийг нотлох анхан шатны баримт бичиг; /харилцах дансны хуулга, төлбөрийн баримт, нэхэмжлэх, бараа борлуулсан, үйлчилгээний үзүүлсэн орлого, зардлын баримт, шаардлагатай тохиолдолд бараа, ажил, үйлчилгээг борлуулсан тухай гэрээ гэх мэт/

4.2.Харьяалах татварын албаны албан татвар суутган төлөгчийн бүртгэл хариуцсан албан хаагч нь хувь хүн, хуулийн этгээдийн бичгээр болон цахимаар ирүүлсэн "Нэмэгдсэн өртгийн албан татвар суутган төлөгчөөр бүртгүүлэх өргөдөл"-ийг хянан шийдвэрлэх бөгөөд татварын албаны ажил хариуцсан нэгжийн дарга хянан баталгаажуулснаар албан татвар суутган төлөгчөөр системд бүртгэгдэж, татвар төлөгчийн гэрчилгээнд өөрчлөлтийн тэмдэглэгээ хийгдэн, бүртгэгдсэн талаар татвар төлөгчид мэдэгдэнэ.

4.3.Энэ журмын 4.2-д заасан шийдвэрийг үндэслэн татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн сангаас QR болон бар код бүхий "Нэмэгдсэн өртгийн албан татвар суутган төлөгчийн гэрчилгээ"-г татвар төлөгчийн цахим татварын систем болон цахим хаягаар илгээж, "Нэмэгдсэн өртгийн албан татвар суутган төлөгчөөр бүртгүүлэх өргөдөл"-ийг татвар төлөгчийн хувийн хэрэгт хадгална.

4.4.Энэ журмын 2.1.2-т заасан үндэслэлээр албан татвар суутган төлөгчөөр бүртгүүлэх шаардлагыг хяналт шалгалт хийсэн татварын улсын байцаагч Татварын ерөнхий хуулийн 79 дүгээр зүйлийн 79.4.2-т заасан шаардах хуудас болон татварын нөхөн ногдуулалтын актыг татвар төлөгчид гардуулж, мэдээллийг харьяалагдах татварын албаны нэмэгдсэн өртгийн албан татвар суутган төлөгчийн бүртгэлийн ажил хариуцсан нэгжид тухай бүр хүргүүлнэ.

4.5.Энэ журмын 4.1-д заасан хугацаанд нэмэгдсэн өртгийн албан татвар суутган төлөгчөөр бүртгүүлэх өргөдөл гаргаагүй хувь хүн, хуулийн этгээдэд татварын албанаас Татварын ерөнхий хуулийн 79 дүгээр зүйлийн 79.4.2-т заасны дагуу албан татвар суутган төлөгчөөр бүртгүүлэх тухай шаардах хуудас хүргүүлнэ.

4.6.Хувь хүн, хуулийн этгээд нь энэ журмын 4.5, 4.6-д заасан шаардах хуудсыг хүлээн авснаас хойш ажлын 3 өдөрт багтаан харьяалах татварын албанд "Нэмэгдсэн өртгийн албан татвар суутган төлөгчөөр бүртгүүлэх өргөдөл" –ийг ирүүлнэ.

4.7.Шаардлагатай тохиолдолд татварын алба хувь хүн, хуулийн этгээдийн албан татвар суутган төлөгчөөр бүртгүүлэх үндэслэл, санхүү, татварын тайланд тусгасан борлуулалтын орлогын үнэн зөв, бодитой эсэхийг нягтлан шалгаж болно.

4.8.Энэ журмын 4.7-д заасан нягтлах шалгалтыг нягтлан бодох бүртгэлийн анхан шатны баримтад үндэслэхийн зэрэгцээ Татварын ерөнхий хуулийн 19 дүгээр зүйлд



заасан нийтлэг ажиллагааг хэрэгжүүлэх замаар өргөдөл хүлээн авсан татварын алба хэрэгжүүлнэ.

4.9.Албан татвар суутган төлөгчөөр бүртгэх үндэслэлгүй эсхүл шаардлага хангаагүй хувь хүн, хуулийн этгээдэд энэ тухай хуулийн этгээдийн бүртгэлтэй гар утас, цахим хаягаар мэдэгдэх бөгөөд шалтгааныг нь тодорхой дурдсан байна.

4.10.Албан татвар суутган төлөгчөөр бүртгүүлсэн хувь хүн, хуулийн этгээдийн албан татвар суутган төлөгч болсон өдрийг тодорхойлохдоо Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.19 дахь заалтыг баримтална.

Тав. Нэмэгдсэн өртгийн албан татвар суутган төлөгчийн бүртгэлд нэмэлт,  
өөрчлөлт оруулах

5.1.Татварын ерөнхий хуулийн 26 дугаар зүйлийн 26.4 дэх хэсэгт заасны дагуу албан татвар суутган төлөгчийн бүртгэлийн мэдээлэл татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд өөрчлөгдөх бүрт нэмэгдсэн өртгийн албан татвар суутган төлөгчийн гэрчилгээнд өөрчлөлтийн тэмдэглэгээ хийгдэнэ.

Зургаа. Нэмэгдсэн өртгийн албан татвар суутган  
төлөгчийн бүртгэлээс хасах

6.1.Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.8-д заасны дагуу суутган төлөгчөөр бүртгүүлснээс хойшхи дараалсан 12 сарын албан татварын тайлангаар албан татвар ногдох орлогогүй, эсхүл орлогын хэмжээ нь албан татвар суутган төлөгчөөр бүртгүүлсэн босгын хэмжээнд хүрээгүй, үйл ажиллагаа явуулаагүй нь нотлогдсон албан татвар суутган төлөгчийг харьяалагдах татварын албаны даргын тушаалаар төрлийн бүртгэлээс хасна.

6.2.Харьяа татварын алба нь албан татвар суутган төлөгчийн бүртгэлээс хасахад дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ .

6.2.1.Эрсдэлийн удирдлагын асуудал эрхэлсэн нэгж нь энэ журмын 6.1-д заасан шаардлагад нийцсэн татвар төлөгчийн эрсдэлийн төвшинг тооцон, эрсдэл өндөртэй татвар төлөгчийн нэмэгдсэн өртгийн албан татварын ногдуулалт, төлөлтийн байдалд хяналт шалгалт хийлгэхээр Хяналт шалгалтын асуудал хариуцсан нэгжид шилжүүлж, эрсдэлгүй эсхүл эрсдэл багатай татвар суутган төлөгчийг тухайн татвар төлөгчийн нэмэгдсэн өртгийн албан татварын бүртгэлийн ажил хариуцсан нэгжид шилжүүлнэ.

6.2.2.Эрсдэлгүй эсхүл эрсдэл багатай албан татвар суутган төлөгчийг эрсдэлийн удирдлагын нэгжээс гаргасан дүгнэлтийг үндэслэн албан татвар суутган төлөгчийн төрлийн бүртгэлээс хасна.

6.2.3.Хяналт шалгалтын асуудал хариуцсан нэгж нь албан татвар суутган төлөгчийг бүртгэлээс хасах ажлыг хүлээн авснаас хойш ажлын 20 өдөрт багтаан татварын хяналт шалгалт хийж, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2.2-т заасны дагуу өөрт үлдээсэн бараанд нэмэгдсэн өртгийн албан татвар ногдуулж, "Нэмэгдсэн өртгийн албан татварын ногдуулалт, төлөлтийг баталгаажуулсан акт" үйлдэнэ.

6.2.4.Татварын хяналт шалгалтаар дараалсан 12 сарын борлуулалтын орлого 50 сая болон түүнээс дээш төгрөг болох нь тогтоогдсон бол татварын төрлийн бүртгэлээс хасахгүй.

6.2.5.Албан татвар суутган төлөгчийн бүртгэлээс хасахдаа нэмэгдсэн өртгийн албан татварын илүү, дутуу үлдэгдлийг холбогдох журмын дагуу шийдвэрлэнэ.

6.2.6.Татвар төлөгчийн харьяалах татварын албаны даргын тушаал гарсан өдрөөс татвар төлөгчийг албан татвар суутган төлөгчийн бүртгэлээс хасагдсанд тооцож ба энэ тухай татвар төлөгчийн гэрчилгээ болон албан татвар суутган төлөгчийн гэрчилгээнд хасагдсан тэмдэглэгээ хийгдэнэ.

6.2.7.Нэмэгдсэн өртгийн албан татвар суутган төлөгчийн гэрчилгээг татвар төлөгчийн цахим хувийн хэрэгт хадгална.

6.3.Албан татвар суутган төлөгчийн бүртгэлээс хасагдсан нь тухайн этгээдийн албан татвар суутган төлөгч байх үеийн үүргээс чөлөөлөгдөхгүй бөгөөд албан татвар суутган төлөгчөөр дахин бүртгүүлэхгүй байх үндэслэл болохгүй.

6.4.Татварын алба улсын хэмжээнд албан татвар суутган төлөгчөөр бүртгэгдсэн болон бүртгэлээс хасагдсан хувь хүн, хуулийн этгээдийн жагсаалтыг татварын албаны цахим хуудсаар улирал бүр мэдээлнэ.

#### Долоо. Маргааныг хянан шийдвэрлэх

7.1.Хувь хүн, хуулийн этгээд нь албан татвар суутган төлөгчөөр бүртгэх, бүртгэлээс хасах үйл ажиллагаатай холбогдсон гомдлоо тухайн татварын албаны дээд шатны татварын албаны даргад гаргана.

7.2.Дээд шатны татварын албаны шийдвэрийг хүлээн зөвшөөрөхгүй бол шүүхээр шийдвэрлүүлнэ.



ТЕГ-ын даргын 20.. оны .. дугаар сарын ..-ны  
өдрийн .... дугаар тушаалын 6 дугаар хавсралт



Нэмэгдсэн өртгийн  
албан татвар суутган төлөгчийн  
ГЭРЧИЛГЭЭ №

1.	РД:			
2.	ТТНэр:			
3.	ТТД:			
4.	Улсын бүртгэлд бүртгэгдсэн он, сар, өдөр:			
5.	Эрхлэх үйл ажиллагаа:			
6.	Үйл ажиллагаа явуулж буй хаяг:			
7.	Удирдлагын овог, нэр, утасны дугаар:			
8.	Харилцах банк, дансны дугаар:			
9.	Хүчинтэй эсэх:			
10.	Гэрчилгээ олгосон:	Татварын алба:	Гэрчилгээний дугаар:	Огноо:
11.	Гэрчилгээ хүчингүй болгосон:	Татварын алба:	Гэрчилгээний дугаар:	Огноо:

